

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 04 ДҮГЭЭР
САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын
албаны үйл ажиллагааны мэдээлэл**

2023 оын 04 дүгээр сарын 14-ний өдөр аймгийн ИТХ-ын ажлын алба, “Эмэгтэйчүүдийн манлайлал сүлжээ” байгууллага хамтран аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эмэгтэй төлөөлөгчдийг хамруулан “Оролцоно төлөөлнө” чуулга уулзалтыг зохион байгууллаа. Чуулга уулзалтад аймаг, сумдын 90 гаруй төлөөлөгч эмэгтэйчүүд оролцож, улс төрийн үйл ажиллагаанд эмэгтэй манлайлагчдын оролцоог нэмэгдүүлэхийн ач холбогдлыг олон нийтэд таниулах, олон нийтийн дунд эмэгтэй төлөөлөгчдийг дэмжих эерэг хандлагыг бий болгох зэрэг асуудлаар сургалт, хэлэлцүүлэг өрнүүлэн, харилцан туршлага солилцсон байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Алсын хараа 2050” урт хугацааны бодлого, “Хот, хөдөөгийн сэргэлт” дунд хугацааны бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд “Нээлттэй Архангай” хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлан, хэрэгжүүлж эхлээд байна.

Дээрхи бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Архангай аймгийн түүхт 100 жилийн ойг угтсан бүтээлч ажлын хүрээнд аймгийн Засаг даргын санаачилгаар “Архангай 100-Соёлын хөгжил”, “Архангай 100-Боловсролын хөгжил”, “Архангай 100-Эрүүл мэндийн хөгжил” форумыг 2023 оны 03 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү 3 өдрийн форумд УИХ, ЗГ-ын гишүүд, холбогдох яамдын болон аймаг орон нутгийн удирдлага, боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын албан хаагчид, эцэг эх, асран хамгаалагчид, суралцагчид, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн холбогдох ажилтнууд нийт 600 гаруй хүн оролцлоо.

2023 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг Архангай аймагт зохион байгуулж, иргэд олон нийтийн санал сэтгэгдлийг сонслоо.

2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж 3 дугаар сард өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг танилцуулж, Архангай аймаг дахь Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газраас цаг үеийн ажил, анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж аймгийн удирдлагууд удирдах ажилтнуудад 17 үүрэг даалгавар өгч, цаашид анхаарах ажлын чиглэлийг танилцуулсан. Мөн аймгийн Засаг дарга аймгийн 100 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд сумдын удирдлагуудтай уулзаж, санал солилцлоо.

Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөл 2023 оны 03 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд Архангай аймгийн төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтыг хууль, журмын дагуу зохион байгуулж нийт 130 сул орон тооны сонгон шалгаруулалт зарласнаас 38 сул орон тоог нөхсөн.

Мөн Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын тусгай шалгалтыг Архангай аймагт 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулаар 19 сул орон тоог нээлттэй зарласан, бэлтгэл ажлыг хангаж байна.

Улсын Онцгой комиссын нарийн бичгийн даргаар Т.Баярхүүгээр ахлуулсан ажлын хэсэг 04 дүгээр сарын 17-ны өдөр Архангай аймагт ажиллаж, энэ үеэр аймгийн Онцгой комисс хуралдаж, аймгийн Онцгой комиссын дарга өвөлжилт, хаваржилтад бэлтгэсэн байдал, хүндэрсэн нөхцөл байдалд ямар арга хэмжээ авч ажилласан талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийлээ.

Архангай аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг угтсан “Архангай-100 Бидний оролцоо” тохижилтын аяны хүрээнд Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа

явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, баг, айл өрхүүдийн дунд тэргүүний тохижилттой шилдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллага, баг шалгаруулах болзолт уралдааныг 04 дүгээр сарын 01-нээс 06 дугаар сарын 30-ны хооронд зарласан.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Төсвийн орлого

2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн дүнгээр улсын төсвийн орлогод өссөн дүнгээр 959,759.9 төгрөг төвлөрүүлэхээс 1,071,196.4 төгрөг төвлөрүүлж, биелэлт 111,6 хувь, аймгийн төсвийн орлогод өссөн дүнгээр 1,069,031.0 төгрөг төвлөрүүлэхээс 1,189,860.4 төгрөг төвлөрүүлж, биелэлт 111,3 хувь, сумын төсвийн орлогод өссөн дүнгээр 3849888.5 мянган төгрөг төвлөрүүлэхээс 3990605.8 мянган төгрөг төвлөрүүлж, биелэлт 103.7 хувь байна.

Тендер, худалдан авах ажиллагаа

Архангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч 2023 онд орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 7455.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 53 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлуулан, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 31-ний дотор 100 хувь цахимаар зохион байгуулахаар бүх тендерийг зарласан. Тендер шалгаруулалтад оролцох аж ахуйн нэгжүүдийн тоо цөөн, зарим тендерүүд 3-4 удаагаа зарлагдаж байгаагаас хугацаа алдах тохиолдол байна. Өнөөдрийн байдлаар 832.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Хөрөнгө оруулалт

2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 108,850,8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан бөгөөд 77,017,4 сая төгрөгийн 36 төсөл арга хэмжээний эрх шилжиж ирсэн.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4,278,3 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөрөнгийн их засвараар 1,664,1 сая төгрөгийн 24 төсөл арга хэмжээ тус тус хэрэгжихээр батлагдсан.

Санхүүгийн хяналт

Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, аймгийн Биеийн тамир спортын газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн 36.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлж, 4 төрлийн актаар 8.4 сая төгрөгийн зөрчилт үйлдэлд нөхөн төлбөрийн акт тогтоож аймгийн төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн.

Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжийн дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаа, нийгмийн даатгалын сангуудад хяналт шалгалт хийж, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч 3.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага тус тус хүргүүллээ.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Гамшиг осол

2023 оны 4 дүгээр сард 5 удаагийн гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлага мэдээлэл ирсэн байна. Үүнд: объектын гал түймэр 2, хээрийн түймэр 1, тусламж үйлчилгээний дуудлага 1, мал амьтны гоц халдварт өвчин 1 удаа тус тус ирсэн байна.

Дээрх гамшиг ослын дуудлаганд онцгой байдлын газрын алба хаагч болон мэргэжлийн ангийн 46 алба хаагч, 18 техник хэрэгсэлтэй ажиллаж 87,5 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 4 сарын байдлаар нийт 726 дуудлага, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 277, зөрчлийн шинжтэй 449 гомдол,

мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 110 буюу 13.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2023 оны эхний 4 сарын байдлаар аймгийн хэмжээнд 119 холбогдогчтой 428.8 сая төгрөгийн хохиролтой 118 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хэрэг 69 буюу 36.9 хувь, холбогдогч нь 41 буюу 25.6 хувиар тус тус буурсан байна. Нийт үйлдэгдсэн гэмт хэргийн 24 буюу 20.3 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 23 буюу 19.5 хувийг хулгайлах төрлийн гэмт хэрэг, 16 буюу 13.5 хувийг хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, 7 буюу 5.9 хувь нь авто ослын гэмт хэрэг, 16 буюу 13.5 хувийг залилах гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Шүүх шинжилгээний хэлтэс 2023 оны 04 дүгээр сард шүүх эмнэлгийн шинжилгээ 43, криминалистикийн шинжилгээ 8, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 40, 16 тусгай шинжилгээ хийсэн байна.

2023 оны 04 дүгээр сард Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2622878,3 төгрөгийн мөнгөн дүн бүхий 392 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 25, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 7.6 байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээ

2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар дараах бүртгэлийг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Иргэний бүртгэл

Төрсний бүртгэл – 137

Овог эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл - 2

Эцэг /эх/ тогтоосны бүртгэл - 3

Гэрлэсний бүртгэл - 30

Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл - 2

Үрчилсний бүртгэл - 1

Нас барсны бүртгэл – 50

Шинээр иргэний үнэмлэх олгосон – 99

Дахин олгосон – 62

Солиулсан - 182

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл

Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 38

Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл – 19

Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл - 31

Худалдах худалдан авах гэрээ – 82

Бэлэглэлийн гэрээ – 17

Барьцааны эрхийн бүртгэл – 330

Өв залгамжлал – 4

Хамтран өмчлөгч өөрчлөгдөх - 6

Лавлагаа – 5

Бусад эрхийн бүртгэл – 16

Хууль хяналтын байгууллагад нийт 28 лавлагааг гарган хүргүүлсэн. Дээрхи бүртгэлүүдийг хийж үйлчилгээний хөлс 6878608 төгрөг, тэмдэгтийн хураамжид 399239 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 10948218 төгрөгийг тус тус улсыг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэл

Шинээр бүртгүүлсэн – 15

Өөрчлөлт – 30

Тамганы хяналтын дугаар олгосон – 33

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсрол

Боловсролын салбарын бүх шатны байгууллагын удирдлага, багш, ажилтан, албан хаагчид, сурагчид, тэдний эцэг эх, асран хамгаалагчид өөрсдийн хийх, хийж чадах зүйлийг тодорхойлж аймгийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллах зорилготой “Боловсролын хөгжил форум”-ыг 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгууллаа.

Форумд УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэг, Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Г.Сайханбаяр, аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид, БЕГ-ын дарга Т.Ням-Очир, БСҮХ-ийн захирал М.Итгэл, БҮТ-ийн захирал Л.Ганбат, аймгийн БШУГ-ын дарга Ц.Мөнхбат, сумдын ЕБС-ын захирал, хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нар, багш, сурагч, эцэг эхчүүдийн төлөөлөл 300 гаруй хүн оролцсон. Форумд оролцогчид “Мэдье-эрхэмлэе-дэмжье-суралцъя-хамтаръя” уриатай төрийн удирдлага, боловсролын удирдлага, багш, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид гэсэн түвшинд зөвлөмж уриалгыг баталлаа.

Соёл урлаг

04 дүгээр сарын 10-ны өдөр аймгийн ЗДТГ, Соёл, урлагийн газар хамтран “Архангай-100 Эртний төрт улсуудын өлгий нутаг” эрдэм шинжилгээний хурлыг Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Тус хуралд ШУА-ийн Археологийн хүрээлэн, МУИС-Улаанбаатар сургууль, МУИС-ийн Антропологи, археологийн тэнхим, Чингис хаан музей болон бусад байгууллагын эрдэмтэн судлаачид, профессорууд сүүлийн үеийн судалгааны шинэ үр дүн болох Хүннү, Түрэг, Уйгур, Эзэнт гүрэн, нийслэл хотын шилжилт, нүүдэлтэй холбоотой сонирхолтой илтгэлүүдийг танилцуулсан.

“Архангай-100 Хүүхдийн урлаг, спортын наадам”-ыг 04 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан бөгөөд наадмын урлагийн дөрвөн төрөлд аймгийн төвийн 6 сургууль, 18 сумын 1200 гаруй хүүхэд, спортын дөрвөн төрөлд аймгийн төвийн 6 сургууль, 13 сумын 1000 гаруй хүүхэд оролцож хурд хүч авъяас чадвараа сорьсон байна.

Архангай аймгийн соёлын салбарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, салбар хоорондын хамтын ажиллагаа, хөгжлийн гарцыг тодорхойлох зорилготой “Соёлын хөгжил форум” 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгууллаа. Тус форумд УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Г.Сайханбаяр, аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид, Соёлын яамны Соёлын бодлогын хэрэгжилтыг зохицуулах газрын дарга Д.Наранцэцэг тэргүүтэй ажлын хэсэг, сумдын соёлын төвүүд, аймгийн ХДТ, Музей, Номын сан, Гэрэл зурагчдын холбоо, Зураач урчуудын холбоо, соёлын бүтээл үйлдвэрлэгч иргэд зэрэг 200 гаруй хүн оролцов. Форумд оролцогчид салбарын өмнө тулгамдаж буй асуудлаа хэлэлцэн хэрхэн шийдвэрлэх, хэрэгжүүлэх санал зөвлөмжийг бодлого боловсруулагчид, аймаг орон нутгийн удирдлага, соёлын байгууллагууд, иргэд олон нийт гэсэн түвшинд гаргаж баталлаа.

Эрүүл мэнд

Хүн амыг зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 0-5 насны 113, 6-17 насны 830, 18-30 насны 96, 31-45 насны 157, 46-60 насны 123, 61-ээс дээш насны 23, нийт 402 иргэн хамрагдсан.

Эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлаар хамтын ажиллагааг сайжруулан, хөрөнгө оруулалт, эмнэлгийн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн салбарын хөгжлийг хангах гарцыг олох зорилгоор “Архангай 100 Эрүүл мэндийн хөгжил” форумыг 2023 оны 03 сарын 29-ний өдөр УИХ-ын гишүүд, ЭМЯ, ЭМДЕГ-ын төлөөлөл, орон нутгийн удирдлага, эрүүл мэндийн салбарын удирдлага эмч мэргэжилтэнүүдийн төлөөлөл 160 оролцогчийг хамруулан зохион байгуулсан.

Форумын нэгдсэн хуралдаанаар Архангай аймгийн эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, саналыг танилцуулан, салбартаа үр бүтээлтэй ажиллаж буй 18 ажилтаныг ЭМЯ-ны шагналаар шагнаж, 7 байгууллагад эмнэлгийн тоног төхөөрөмж гардуулсан.

Цэргийн төв эмнэлгийн хөдөлгөөнт үзлэгийн баг 2023 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн Хашаат, Хотонт, Төвшрүүлэх, Цэнхэр, Булган, Батцэнгэл гэсэн 6 суманд үзлэг хийж, нийт 2357 иргэн хамрагдсан. Үүнээс 3-р шатлалд оношилгоонд хамрагдах шаардлагатай-15, хавдрын шижигтэй-10, хавдар илэрсэн 3 иргэн байна.

Архангай аймгийн зудын эрсдэлтэй байгаа 19 сумын 77 багийн айл өрхүүдээр үзлэг оношилгоо хийж нийт отроор яваа 5728 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлэв. Үүнд: 0-5 настай хүүхэд 952, жирэмсэн эх 190, архаг хууч өвчтэй ахмад настан 1201, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 419 иргэдэд гэрийн эргэлт үзлэг зохион байгуулж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон яаралтай тусламж үйлчилгээний тасралтгүй бэлэн байдлыг ханган, зөвлөгөө өгч, нүүдлийн эмийн сан 2453 айл өрхөд ажиллуулсан.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, гэр бүл хүүхэд залуучууд

2023 оны 04 дүгээр сард 16.4 мянга орчим тэтгэвэр, тэтгэмж авагчдад 24,6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь шуурхай олгож, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан аж ахуй нэгж байгууллагууд болон сайн дураар нийгмийн даатгалын шимтгэл төлөгч иргэд даатгуулагчдад сургалт зохион байгуулсан.

Залуучуудыг аймгийн 100 жилийн ойн хүрээнд өөрсдийнхөө эргэн тойронд юуг хийж чадах вэ, өөрийгөө хэрхэн бүтээж, бусдад буюу нийгмийн сайн сайхан, эерэг хандлагыг нэмэгдүүлэхэд хэрхэн нөлөөлөх, үр хүүхэд, гэр бүл, хамт олондоо хэрхэн эерэг хандлагыг түгээж, дадал болгож чадах тухай мэдлэг олгох зорилготой “Архангай 100 Залуучуудын оролцоо” аяныг 05 дугаар сарын 01-нээс 06 дугаар сарын 01-ний хооронд зохион байгуулахаар төлөвлөж аяны нээлтийг 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгууллаа.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

2022-2023 онд 19 сумын 101 багийн 8207 хот айлд 19.4 мянган малчин болон мал бүхий өрхийн 5,8 сая толгой мал хаваржиж байна.

Нийт мал сүргийн 5.8 хувь нь хорогдсоноос, тэмээ 61 толгой буюу 3.5%, адуу 24360 толгой буюу 5.2 %, үхэр 44703 толгой буюу 5.5 %, хонь 155606 толгой буюу 5.1%, ямаа 117202 толгой буюу 7.7 %, нийт 341932 толгой мал хорогдож, бод малын 5.4%, бог малын 5.9 % нь хорогдсон байна.

Энэ онд аймгийн хэмжээнд 2,1 сая толгой хээлтэгч мал төллөхөөс 04 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 51,6 хувь буюу 1116329 мянган толгой хээлтэгч мал төллөсөн байна. Үүнээс ингэ-16 толгой 4.8%, гүү- 20084 толгой 15%, үнээ 60399 толгой 24.1%, эм хонь- 723042 толгой 59,9 %, эм ямаа- 323880 толгой 55.6 % нь төллөж төл мал 81,6 хувьтай бойжиж байна. Төллөвөл зохих нийт хээлтэгч бодын 18.5%, богийн 58.5 хувь нь төллөсөн, гарсан төлийн 18.3 хувь хорогдсон.

2023 оны 01 дүгээр сард Улсын Онцгой комиссын шийдвэрээр олгосон 50 хувийн хямдралтай үнэтэй 285 тн тэжээлийг /хивэг/ 19 суманд 13-15 тн-р олгосон. 02 дугаар сард аймгийн Онцгой комиссын шийдвэрээр хөнгөлөлттэй үнээр овъёос, будааны холимог тэжээлийг Булган, Хашаат, Батцэнгэл, Өндөр-Улаан, Хотонт, Эрдэнэмандал, Цэцэрлэг, Ихтамир, Хайрхан сумдад 5-8 тн-р, нийт 72 тн тэжээлийг хуваарийн дагуу олгосон.

Мөн аймгийн Онцгой комиссын 04 дүгээр сарын 03-ны өдрийн шийдвэрээр аймгийн Мал хамгаалах сангаас 700 шуудай хивэг, 500 шуудай хорголжин тэжээлийг 50 хувийн хямдралтай үнээр, 700 шуудай ашигт долооцыг үнэгүйгээр Хангай, Өгийнуур, Батцэнгэл, Өлзийт, Цэнхэр, Төвшрүүлэх, Чулуут, Ихтамир, Өндөр-Улаан, Эрдэнэбулган зэрэг 10 суманд, 04 дүгээр сарын 13-ны шийдвэрээр хивэг 50 хувийн хямдралтай үнээр Эрдэнэмандал, Чулуут, Цахир, Өлзийт, Ихтамир, Өндөр-Улаан, Жаргалант, Батцэнгэл, Тариат, Цэцэрлэг, Хайрхан, Хангай, Эрдэнэбулган зэрэг 13 суманд 6-9 тн тэжээл тус тус олгосон.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/131 дүгээр захирамжийг үндэслэн 19 суманд Засаг даргын захирамж гарч орон нутгийн аж ахуй нэгж, байгууллага, нөхөрлөл,

малчдыг малын сэг зэм устгах ажилд татан оролцуулж, орчны цэвэрлэгээ сэг зэм устгал, халдваргүйтгэлийн ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.

2023 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар сумдын Мал эмнэлгийн улсын байцаагчийн хяналтан дор 4955 сэг, зэмийг цуглуулж зааврын дагуу устгаж, 48498 м² талбайг халдваргүйжүүлж, ажлын гүйцэтгэл 17,5 хувьтай байна.

Архангай аймгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд төрөөс хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийг танилцуулж, зөвлөгөө өгөх, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон гарц шийдлийг олох зорилготой “Архангай-100 Тариаланчдын хэлэлцүүлэг”-ийг 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун (цахимаар), аймгийн Засаг дарга, аймгийн ХХААГ-ын дарга, ХААИС-ийн багш нар, 19 сумын Засаг дарга, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэд, аж ахуйн нэгж зэрэг 100 гаруй хүн оролцсон.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин

“Архангай-100 Бидний оролцоо” тохижилтын аяны хүрээнд орчны бохирдлыг бууруулах, иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулах зорилгоор 04 дүгээр сарын 22-ны өдөр “Бүх нийтийн цэвэрлэгээ”-г зохион байгуулж нийтийн эзэмшлийн гудамж талбай, орон сууц, гэр хороолол, ААН байгууллагын ойр орчим, гол, горхины голдирол, улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуух хог хаягдлыг цэвэрлэлээ.

Бүх нийтийн цэвэрлэгээнд Эрдэнэбулган суман үйл ажиллагаа явуулж буй 200 гаруй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын 400 гаруй албан хаагч оролцож 45 тн хог хаягдлыг цэвэрлэж хогийн нэгдсэн цэгт хаясан.

Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Хөрсний бохирдол, хог хаягдлыг бууруулах, стандартын бус ариун цэврийн байгууламж болох нүхэн жорлонг буулгах, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Орхон-Чулуут голын сав газрын захиргаа, Тариат сумын ЗДТГ, Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа хамтран Хорго-Тэрхийн байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 60 нүхэн жорлонг буулгаснаас 33 нүхэн жорлонг өнгө үзэмжийг нь сайжруулах ба бусад стандартын шаардлага хангаагүй нүхэн жорлонг бүрэн буулгаж, ариутгал хийж булав. Тус бүс нутагт стандартын шаардлага хангасан 8 ариун цэврийн байгууламж байна.

Барилга байгууламж, дэд бүтэц

"Барилгын салбарын инженер, техникийн ажилчдын зөвлөгөөн-2023" 04 дүгээр сарын 21-ны өдөр аймгийн ЗДТГ-ийн хурлын их танхимд зохион байгуулагдлаа.

Аймгийн ЗДТГазар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, аймгийн Барилгачдын холбоо хамтран аймгийн хэмжээнд барилга угсралт, материал үйлдвэрлэл, зураг төсвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 32 аж ахуйн нэгж, байгууллагын захирал, инженер техникийн ажилчдад зориулан барилгын салбарт шинээр батлагдсан норм ба дүрэм, барилга угсралт, материалын чанар аюулгүй байдал, зураг төсвийн үнэ бүрдэлт, шинэ дэвшилтэд технологийг танилцуулах, барилгын салбарт тулгамдаж буй асуудлаар ярилцах зорилгоор зөвлөгөөнийг зохион байгуулж тус арга хэмжээнд Барилга хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төв, Барилгын инженерүүдийн холбоо ТББ, “Барилгын төсөвчдийн холбоо” ТББ, “Бүрэн трейд девелопмент” ХХК, “Динамик” ХХК-ууд урилгаар оролцлоо.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ажлын хэсэг “Эрдэнэт” үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Өндөр-Улаан, Батцэнгэл, Хотонт, Хашаат сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийг шинэчлэх ажилд техникийн хяналт хийж, Чулуут, Хангай, Өндөр-Улаан, Цэцэрлэг сумдын ЭМТ-ийн 2024 онд хийгдэх Ариун цэврийн байгууламжийн ажлын зургийн даалгавар боловсруулах ажилтай газар дээр нь танилцсан байна.

АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----